



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ДОА-2021/83/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	10
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.05 № 14

танай _____ -ны № _____ -т

ЦАГААН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.СЭНДМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,540,747.41	115,057,497.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	-	2,544,279.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,544,279.00
35	БАРАА МАТЕРИАЛ	138,540,747.41	112,513,218.62
351	Түүхий эд материал	74,312,696.26	49,119,230.26
35110	Тусгай зориулалттай материал	74,312,696.26	46,976,130.26
35130	Эм боох материал	-	2,143,100.00
354	Хангамжийн материал	45,043,051.15	35,678,988.36
35410	Бичиг хэргийн материал	33,004,101.15	23,228,631.36
35420	Аж ахуйн материал	12,038,950.00	8,806,100.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,822,707.00
35460	Хүнсний материал	-	1,821,550.00
35600	Мал амьтад	19,185,000.00	27,715,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,873,063,079.97	1,790,047,850.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,873,063,079.97	1,790,047,850.89
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,844,155,079.97	1,761,139,850.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,908,358,992.38	1,908,358,992.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(262,874,802.88)	(316,090,128.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,166,666.64)	(1,749,999.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	301,416,722.54	272,141,211.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(175,371,812.75)	(178,226,027.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137,345,867.72	127,355,050.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,828,430.24)	(56,141,526.79)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,999,400.00	4,993,400.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,224,190.16)	(3,001,120.08)
393	Биет бус хөрөнгө	28,908,000.00	28,908,000.00
39301	Програм хангамж	2,499,600.00	2,499,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,499,600.00)	(2,499,600.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	28,908,000.00	28,908,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,011,603,827.38	1,905,105,348.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,544,279.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,544,279.00
413	Өглөг	-	2,544,279.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,544,279.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,011,603,827.38	1,902,561,069.51
51	Засгийн газрын хувь оролцоо	2,011,603,827.38	1,902,561,069.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,029,009,248.15	1,029,009,248.15
51101	Өмч: - төрийн	1,000,101,248.15	1,000,101,248.15
51102	- төрийн	28,908,000.00	28,908,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(574,159,640.90)	(683,202,398.77)
51210	Өмнөх үеийн үр дүн	(574,159,640.90)	(574,159,640.90)
51220	Тайланг үеийн үр дүн	-	(109,042,757.87)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,556,754,220.13	1,556,754,220.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,011,603,827.38	1,905,105,348.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	907,473,304.10	1,086,935,111.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,885,504.10	27,153,511.07
120	Нийтлэг татварын бус орлого	50,885,504.10	27,153,511.07
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,885,504.10	27,153,511.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,053,817.20	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,355,000.00	9,780,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,476,686.90	17,373,511.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	856,587,800.00	1,059,781,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	757,546,000.00	1,044,092,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	757,546,000.00	968,194,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	75,898,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,041,800.00	15,688,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,725,000.00	14,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	316,800.00	1,188,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	74,000,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	962,960,623.57	1,195,977,868.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	962,960,623.57	1,195,977,868.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	936,508,133.07	1,087,525,358.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	595,643,028.00	702,139,066.00
210101	Үндсэн цалин	448,750,928.00	508,196,085.00
210102	Нэмэгдэл	85,572,100.00	140,767,699.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	61,320,000.00	53,175,281.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,242,366.00	87,145,465.00
210201	Тэтгэврийн даатгал	52,357,872.00	65,566,877.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,972,200.00	7,654,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,777,800.00	2,480,141.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,194,500.00	594,548.00
210205	Эрүүд мэндийн даатгал	11,939,994.00	10,849,799.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,000,000.00	71,401,198.00
210301	Гэрэл, цахилгаан	15,472,718.00	14,710,966.00
210302	Түлш, халаалт	54,926,823.00	56,150,282.00
210303	Цэвэр, бохир ус	600,459.00	539,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,311,017.00	70,358,705.86
210401	Бичиг хэрэг	2,094,700.00	18,577,529.86
210402	Тээвэр, шатахуун	4,436,192.00	1,999,240.00
210404	Ном, хэвлэл	-	1,188,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	880,000.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,780,125.00	47,713,136.00
2105	Нормативт зардал	47,783,698.50	32,960,244.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	195,000.00	2,280,000.00
210502	Хоол, хүнс	46,763,698.50	30,080,244.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	825,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	5,448,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	5,448,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,512,200.00	895,000.00
210702	Дотоод албан томилолт	1,512,200.00	895,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	418,000.00	116,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	238,000.00	116,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,597,823.57	117,060,780.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,450,000.00	6,250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,825,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,322,823.57	110,810,780.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,452,490.50	108,452,510.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,446,565.00	16,853,439.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,446,565.00	16,853,439.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,925.50	91,599,071.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,925.50	91,599,071.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(55,487,319.47)	(109,042,757.87)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(55,487,319.47)	(109,042,757.87)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	856,587,800.00	1,059,781,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	856,587,800.00	1,059,781,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	757,546,000.00	1,044,092,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	757,546,000.00	968,194,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	75,898,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,041,800.00	15,688,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,725,000.00	14,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	316,800.00	1,188,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	74,000,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	856,587,800.00	1,059,781,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	856,587,800.00	1,059,781,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	830,135,309.50	951,168,440.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,235,400.00	702,139,066.00
210101	Үндсэн цалин	450,343,300.00	508,196,085.00
210102	Нэмэгдэл	85,572,100.00	140,767,699.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	61,320,000.00	53,175,281.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,649,994.00	87,145,465.00
210201	Тэтгэврийн даатгал	50,765,500.00	65,566,877.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,972,200.00	7,654,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,777,800.00	2,480,141.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,194,500.00	594,548.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,939,994.00	10,849,799.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,000,000.00	73,082,005.00
210301	Гэрэл, цахилгаан	15,472,718.00	14,710,966.00
210302	Түлш, халаалт	54,926,823.00	57,831,089.00
210303	Цэвэр, бохир ус	600,459.00	539,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,711,017.00	26,491,280.00
210401	Бичиг хэрэг	2,094,700.00	3,944,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,436,192.00	2,141,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-
210404	Ном, хэвлэл	100,000.00	1,188,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,883,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,080,125.00	16,334,140.00
2105	Нормативт зардал	47,783,698.50	43,020,724.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	195,000.00	2,780,000.00
210502	Хоол, хүнс	46,763,698.50	31,741,144.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	825,000.00	8,499,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000.00	5,178,000.00
210602	Тавилга	10,000,000.00	-
210604	Урсгал засвар	3,000,000.00	5,178,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,512,200.00	895,000.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	1,512,200.00	895,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	418,000.00	116,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	238,000.00	116,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,825,000.00	13,100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,825,000.00	7,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,452,490.50	108,613,160.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,446,565.00	17,014,089.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,446,565.00	17,014,089.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,925.50	91,599,071.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,925.50	91,599,071.00
213304	Хөрөнгийн	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	=	=
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,029,009,248.15	1,556,754,220.13	-574,159,640.90	2,011,603,827.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,029,009,248.15	1,556,754,220.13	-574,159,640.90	2,011,603,827.38
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайланг үеийн үр дүн				0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,029,009,248.15	1,556,754,220.13	-574,159,640.90	2,011,603,827.38
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,029,009,248.15	1,556,754,220.13	-574,159,640.90	2,011,603,827.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,029,009,248.15	1,556,754,220.13	-574,159,640.90	2,011,603,827.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	-109,042,757.87	-109,042,757.87
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,029,009,248.15	1,556,754,220.13	-683,202,398.77	1,902,561,069.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,048,573,500.00	952,493,729.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,048,573,500.00	952,493,729.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,023,101,300.00	935,479,640.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	765,404,100.00	702,139,066.00
210101	Үндсэн цалин	509,510,300.00	508,196,085.00
210102	Нэмэгдэл	198,893,800.00	140,767,699.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	57,000,000.00	53,175,281.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,675,500.00	87,145,465.00
210201	Тэтгэврийн даатгал	65,059,400.00	65,566,877.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,123,200.00	7,654,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,530,800.00	2,480,141.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,654,000.00	594,548.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,308,100.00	10,849,799.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,084,700.00	73,082,005.00
210301	Гэрэл, цахилгаан	20,271,100.00	14,710,966.00
210302	Түлш, халаалт	52,273,600.00	57,831,089.00
210303	Цэвэр, бохир ус	540,000.00	539,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,186,500.00	18,167,480.00
210401	Бичиг хэрэг	3,944,500.00	3,944,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,158,900.00	2,141,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариугал	2,883,100.00	2,883,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,200,000.00	9,199,140.00

2105	Нормативт зардал	55,703,300.00	43,020,724.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,780,000.00	2,780,000.00
210502	Хоол, хүнс	44,423,300.00	31,741,144.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,500,000.00	8,499,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,813,600.00	2,813,000.00
210604	Урсгал засвар	2,813,600.00	2,813,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	895,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	895,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам	133,600.00	116,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний тө	133,600.00	116,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,100,000.00	8,100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,800,000.00	7,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,472,200.00	17,014,089.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,472,200.00	17,014,089.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,472,200.00	17,014,089.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	757,546,000.00	1,044,092,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	757,546,000.00	1,044,092,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	757,546,000.00	968,194,500.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		75,898,300.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,135,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,135,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,365,000.00
210604	Урсгал засвар	2,365,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,500,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,500,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,500,000.00
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг А.Сэндмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ноос 2021 оны 01 дүгээр сарын 25-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх,
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,195,977.9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 23,919.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,042.8 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	138,540.7	112,513.2	-26,027.5
Үндсэн хөрөнгө	1,873,063.1	1,790,047.8	-83,015.3
Нийт хөрөнгө	2,011,603.8	1,902,561.0	-109,042.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,011,603.8	1,902,561.0	-109,042.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,011,603.8	1,902,561.0	-109,042.8

Авлагын үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 112,513.2 мянган төгрөг болж 26,027.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,790,047.8 мянган төгрөг болж 83,015.3 мянган төгрөгөөр буурсан нь ИТХ-ын тогтоолын дагуу үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 12,425.6 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 15,280.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 90,0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 67,067.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,902,561.0 мянган төгрөг болж 109,042.8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 179,461.8 мянган төгрөгөөр буюу 19.8 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 233,017.2 мянган төгрөгөөр буюу 24.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагдсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,358,617.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,358,617.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 314,524.9 мянган төгрөгөөр бууруулж 1,048,573.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,048,573.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 972,675.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 75,898.3 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 972,675.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 75,898.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 1,048,573.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 956,974.4 мянган төгрөгийг зарцуулж 91,599.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 956,974.4 мянган төгрөг буюу 91,3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 63,265.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл 8,530.0 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 2,017.8 мянган төгрөгөөр, албан томилолтыг 1,105.0 мянган төгрөгөөр, үдийн цай болон хоолны 16,681.3 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал гарснаас үүдэн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 14,500.0 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна.

Үүнээс бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсэд 7,135.0 мянга, урсгал засварт 2,365.0 мянга, хөрөнгө бэлтгэхэд 5,000.0 мянга, нийт 14,500.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 зарлагын 104,749,158 төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Итгэл үзүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,088.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 2,544.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 104,749.1 мянган төгрөгийн, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцсон 2,544,3 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 зарлагын 104,749,158 төгрөгийн гүйлгээг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 2,544,279 төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх "дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2 дахь "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..." гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/83/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 зарлагын 104,749,158 төгрөгийн гүйлгээг байршуулаагүй	104,749,2	Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	А.Сэндэм, Б.Туяа
2	Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан.	2,544.3	Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	А.Сэндэм, Б.Туяа
ДҮН		107,293.5			